



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023. 02.09 № 02/38

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.ЦЭВЭЛМАА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна. Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 32

А/2023/0316

Мандалговь

Зорчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитаар барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т *Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1. 20-д заасан гэрээг байгуулж ажиллах*, Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12-т *Түлсйн болон орон нутгийн тосов, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал харивцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно*, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний" тухай А/407 дугаар захирамжийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг дарга Т.Цэвэлмаа, нягтлан бодогч Э.Хандсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012041478

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сан
Тайланг хугацаа: 2022 оны 4 дүгээр улирал

№	Ажил гүйцээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A	I	3	4	5	6	7	8	9	10
I	Зардал	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй	-	Албан шаардлага хүргүүлэх	Засаг дарга Т.Цэвэлмаа, Санхүүгийн албаны дарга Т.Дуламханд, Нягтлан бодогч Э.Хандсүрэн нарт 2023 оны 02 дүгээр сарын 09-ий танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн	Барилгын тухай хууль, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах арга хэмжээний" тухай А/407 дугаар захирамжийн хэрэг-жилтийг хангаж захиалагчийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллах	Зөрчлийг арилуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	Т.Цэвэлмаа Т.Дуламханд Э.Хандсүрэн
Нийт дүн									

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Т.Батсайхан

Хянасан: Аудитын менежер

Х.Наранцаирал

Хоёр дах шатанд хянасан: Дарга гэргүүлэх аудитор

Р.Мөнхтогтох

Засаг дарга

Санхүүгийн албаны дарга

Нягтлан бодогч

Т.Цэвэлмаа

Т.Дуламханд

Э.Хандсүрэн